



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1153

Шивээговь сум

Спортын бага наадам зохион байгуулах  
 комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, сумын Засаг даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.35 дахь заалт “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд “Сумын Засаг даргын нэрэмжит спортын бага наадам” зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Наранбаатар

(Соёлын төвийн техникч, Спортын арга зүйч)

2. Спортын бага наадмын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, наадмын зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Наадамд зарцуулагдах 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4. Спортын бага наадамд иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн хамруулж, иргэдэд зөв дадал хэвшил олгоход уриалан өндөр түвшинд зохион байгуулалттай ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын  
2022 оны 04-р сарын 20-ны өдрийн  
153 дугаар захирамжийн 1-р хавсралт



**СУМЫН ИРГЭДИЙН ДУНДАХ “СПОРТЫН БАГА НААДАМ”-ЫН УДИРДАМЖ**  
Шивээговь сумын харьяалалтай иргэд оролцоно

Наадмын зорилго

Сум орон нутагт иргэдийн сонирхол хэрэгцээнд тулгуурлан бүх нийтийн биеийн тамир спортын арга хэмжээ тэмцээн наадмыг зохион байгуулах. иргэдийг биеийн тамир спортоор хичээллэн идэвхтэй эрүүл амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Спортын төрөл, Бүрэлдэхүүн

№	Спортын төрөл	Багийн бүрэлдэхүүн	Зохион байгуулах	Зохион байгуулах газар
<b>Үндсэн төрөл</b>				
1	Сагсан бөмбөг	Эрэгтэй-6, эмэгтэй-6 тус бүр 1 дасгалжуулагчтай	Эр-8 мин I Эм-6 мин /2 үе/	Уурхайн зааланд
2	Гар бөмбөг	Эрэгтэй-7, эмэгтэй-7 тус бүр 1 дасгалжуулагчтай	21 оноогоор 3 ээлж	Уурхайн зааланд
3	Теннис	Эрэгтэй-1 Эмэгтэй-1		Уурхайн зааланд
4	Дардас	Эрэгтэй-1 Эмэгтэй-1	Хасагдах системээр	ЗДТГ
<b>Сонгох төрөл</b>				
5	Олс таталт	Эрэгтэй-3 Эмэгтэй-3		ЗДТГ

1.2 Спортын наадмын тов

Спортын наадам 2022 оны 04 сарын 30-ний 08<sup>00</sup> цагаас эхэлнэ

1.3 Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөн нь 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 17<sup>00</sup> цагт Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно Тус техникийн зөвлөгөөнд

зохион байгуулах ажлын хэсэг багийн ахлагч нар оролцоно.

Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч нар тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг маягтын дагуу ирүүлнэ (мэдүүлгийн маягтыг хавсаргав) Багийн мэдүүлэг ирүүлэхдээ тамирчдын цахим үнэмлэхний хуулбарыг хавсаргана

#### 1.4 Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаа

Тэмцээний нээлт 04-р сарын 30-ний өдөр 08<sup>00</sup> цагт Уурхайчдын спорт зааланд хийх тул үйл ажиллагаанд баг тамирчид жигд хувцас, логотой оролцоно /Багууд хаягтай жагсана.

#### Хоёр. Тэмцээн зохион байгуулах, дүгнэх журам

2.1 Тэмцээнд оролцох баг тамирчид багийн ахлагчтай байна

2.2 Тэмцээний үеэр ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд тамирчид багийн ахлагчаар дамжуулан тухайн маргааныг шийдвэрлүүлнэ.

2.3 Тэмцээнд оролцох баг тамирчдыг тухайн баг болон байгууллагын дарга, захирал эрхлэгч нар хариуцан идэвхтэй оролцуулах бөгөөд иргэдийн тэгш оролцоог хангахын тулд байгууллагын ажилтнуудын эхнэр нөхөр үр хүүхэд оролцож болно. /Жич сумын харьяат байх/

2.4 Баг тамирчдын хувцаслалтын байдлыг дүгнэн тэмцээн тус бүр дээр 0-5 баллын оноог ерөнхий шүүгч өгнө.

2.5 Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг маягтын дагуу бичиж өгөх бөгөөд тамирчин спортын зөвхөн 1 төрөлд оролцоно.

2.6 Тоглолтын дэг, хуваарь, эхлэх болон дуусах дарааллыг техникийн зөвлөгөөн дээр сугалаагаар тогтооно. Сугалаа сугалснаас хойш тэмцээнд өөр баг нэмж оруулахгүй.

2.7 Сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд оролцогч багуудыг А. В. С хэсгүүдэд хувааж тойргоор явагдана.

2.8. Дараагийн шатанд шалгарсан багийг олимпийн системээр тоглуулж, төрөл тус бүрт аваргыг шалгаруулж байр эзлүүлнэ

2.9 Хэрэв тэмцээнд цөөн тооны баг оролцохоор бол техникийн зөвлөгөөн дээр ямар системээр тоглохыг шийдвэрлэнэ.

2.10. Тэмцээнд оролцогч сумын харьяат байх бөгөөд наадамд оролцож байгаа тухайн төрөлдөө спортын дэд мастераас дээш цолтой тамирчин оролцохгүй.

2.11 Тэмцээнд харьяалалгүй боловч ажлын онцлогийн дагуу суманд 3-аас дээш жил оршин суусан иргэдийг оролцохыг зөвшөөрнө.

2.12 Тэмцээнд оролцох баг тамирчид энгэрийн болон арын хувийн дугаар бүхий тоглолтын жигд өмсгөлтэй цаг хугацаа болон тэмцээний зохион байгуулалтын шаардлагыг биелүүлэх, нээлтийн болон хаалтын үйл ажиллагаанд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцох, хаяг логотой байх зэрэг шаардлагуудыг хангасан байна

2.1.3 Тэмцээнд харьяалалын бус иргэн оролцуулсан тохиолдолд оролцсон төрлийг хүчингүй болгон. Тэмцээн эхлэхэд талбайдаа бэлэн байх шаардлагатай ба 5 минутанд талбайд гараагүй багт 0 оноо өгнө

#### Гурав. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн, заавар

Спортын бага наадамд албан байгууллага ААН-үүд сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй, эмэгтэй тус тусдаа тоглох ба дараах багийн бүрэлдэхүүнтэй оролцоно.

Үүнд:

1. ЗДТГ, ИТХ, Соёлын төв- хамтарсан баг
2. Шивээ-Овоо ХК-1 баг
3. Шивээ сервис ХХК- 1 баг
4. 3-р цэцэрлэг, Илчлэг шивээ ОНӨҮГ- хамтарсан баг
5. 3-р сургууль- 1 баг
6. Эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсэг- хамтарсан баг
7. 1-р баг- 1 баг
8. 2-р баг- 1 баг
9. 21-р зөрлөг- 1 баг
10. 22-р зөрлөг- 1 баг
11. Хаан банк, Төрийн банк, холбооны салбар- хамтарсан баг
12. Хувийн хэвшил

#### Дөрөв. Шагнал, урамшуулал

4 1 Тэмцээний төрөл тус бүрд нэг, хоёр, гуравдугаар байр эзлүүлж байр эзэлсэн багуудад өргөмжлөл. мөнгөн шагнал олгоно

4 2. Гурван төрлийн нийлбэр дүнг их онооны системээр дүгнэн өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнаана

Сумын Засаг даргын  
2022 оны 04-р сарын 20-ны өдрийн  
113 дугаар захирамжийн 2-р хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ДУНДАХ “СПОРТЫН БАГА НААДАМ”-ЫН ЗАРДАЛ

№	Спортын төрөл	Эзлэх байрны тоо	Тоо хэмжээ	Шагналын дүн	Нийт
1	Сагсан бөмбөг /эр. эм/12 хүн	1-р байр	2.00	100,000	200,000
		2-р байр	2.00	80,000	160,000
		3-р байр	2,00	60,000	120,000
2	Гар бөмбөг /эр. эм/	1-р байр	2,00	100,000	200,000
		2-р байр	2.00	80,000	160,000
		3-р байр	2,00	60,000	120,000
3	Теннис	1-р байр	2,00	40,000	80,000
		2-р байр	2,00	30,000	60,000
		3-р байр	2,00	20,000	40,000
4	дардас	1-р байр	2.00	40,000	80,000
		2-р байр	2.00	30,000	60,000
		3-р байр	2,00	20,000	40,000
5	Олс таталт	1-р байр	1,00	80000	80000
		2-р байр	1,00	60,000	60,000
		3-р байр	1,00	50,000	50,000
6	Багийн нийт тэргүүн байр	1	1	80000	80000
7	Багийн нийт дэд байр	1	1	60000	60000
8	Багийн нийт гутгаар байр	1	1	50000	50000
9	Өргөмжлөл		27	10,000	270,000
10	Жааз		3	10,000	30,000
11	Шүүгчийн зардал	1	2,5	200,000	200,000
Дүн					2 200 000